

## САЛБАР ХУРАЛДААН- 6

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Модератор: Б.Мөнхтуул, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга

---

#### Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн бодлого, шинэчлэл
2. Стратегийн худалдан авалтыг бий болгож буй үйл явц, гэрээлэлт, хяналт
3. Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, тайлагналтад анхаарах асуудлууд
4. Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн танилцуулга

#### НЭГ. ЭРХЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлтэй уялдуулан аймаг, нийслэлийн түвшинд эмнэлгийн зохион байгуулалтыг оновчтой болгох, улс хувийн хэвшлийн нөөцийг хамтад нь төлөвлөж, тусгай зөвшөөрлийг хүн амын хэрэгцээний үнэлгээнд суурилсан олгодог болох.
2. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан тусгай зөвшөөрлийг олгох ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажил үүргийн хуваарийн тушаалыг шинэчлэх, эдийн засгийн тооцоо, эрэлт хэрэгцээ хийх чадавхийг аймаг, нийслэлд бэхжүүлэх
3. Эмнэлгийн стандартыг шинэчилж, уян хатан болгох, эрүүл мэндийн сайдын тушаалаар баталдаг тусламж, үйлчилгээний төрлөөр гарсан эмнэлэг, хүний нөөцийн тоо заасан тушаал шийдвэрийг шинэчлэх (жишээ нь: бэлгийн замын халдварт өвчний удирдамж, Өсвөр үе, сүрьеэгийн удирдамж дээр орон тоо заасан байдаг гэх мэт)
4. Орон нутгийн өмчийн эмнэлгүүд ТУЗ-тай болж ажиллахаар аймгийн ЭМГ-ын шийдвэр гаргах эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхой болгох /Аймаг, нийслэлийн ЭМГ-ын эрх мэдэлгүй хариуцлага хүлээх ажлууд их байдаг./ Эрүүл мэндийн тухай хуулийн томилгооны хэсэг дээр өөрчлөлт оруулах
5. Эмнэлгүүд бие даасан байдлаар ажиллахад оролцогч талуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, ТУЗ-ийн үйл ажиллагаанд хэрхэн оролцох, удирдах гэх мэт Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулинд өөрчлөлт оруулах
6. Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг тусгайлан гаргахгүйгээр одоо мөрдөж буй Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг нэгтгэн шинэчилж цогц байдлаар шинэчлэн найруулах
7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын нэмэгдүүлэхэд онцгой анхаарч архи тамхины онцгой албан татвараас бий болох орлогыг санд төвлөрүүлэх чиглэлд ажиллах

8. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор хамрагдаагүй байгаа иргэдэд чиглэж ажиллах, орон нутгийн иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх

## **ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

### **ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Анагаахын сургуульд элсэгчдийн тоонд хязгаар тавих, квот тогтоох
2. Анагаахын сургуулиудыг стандартчилж магадлах, сургалтын чанарыг сайжруулах
3. Орон нутгаас резидент эмчийн сургалтад суралцаж буй оюутнуудын урамшууллыг бодлогоор дэмжиж олгох, шууд төгссөн болон УБ хотоос суралцаж оюутнуудаас ялгаатай болгох
4. Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтнийг мэргэшүүлэх, чадавхийг дээшлүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах

### **ДӨРӨВ. ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Одоогийн хүчин төгөлдөр эмчилгээ оношилгооны стандарт (MNS) эмнэлзүйн удирдамж, зааварт дүн шинжилгээ хийж, Uptodate цахим платформд байгаа олон улсад ашиглагддаг эмнэл зүйн удирдамжтай уялдуулах
2. Тухайн эмнэлзүйн сэдвээр эмнэлзүйн удирдамж байхгүй тохиолдолд мэргэжлийн салбар зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аль улсын эмнэлзүйн удирдамжыг ашиглахыг шийдэх

### **ТАВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

1. Цэрэг татлага, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг ЭМДын сангаас санхүүждэггүй тусламж, үйлчилгээний санхүүжилтийг холбогдох төрийн байгууллагуудтай хэлэлцэн шийдүүлэх
2. Хөрөнгө оруулалтыг бодит тооцоо, эдийн засгийн үнэлгээн дээр үндэслэн хийх (Засвар үйлчилгээний зардлыг тооцох гэх мэт)
3. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа зэрэг ЭМДС-нд төвлөрөөгүй тусламж, үйлчилгээний санхүүжилтийг шинэчлэх, аргачлал боловсруулахад анхаарч ажиллах
4. ОХБ-ийн тарифыг эмнэлзүйн хүндрэлийн зэргээр нь ангилах, сайжруулах чиглэлд ажиллах
5. Цитологи болон эмгэг судлал, шүүх эмнэлгийн хүрээнд хийгддэг тусламж, үйлчилгээний санхүүгийн эх үүсвэрийг холбогдох салбаруудтай хамтран хэлэлцэж шийдэх

6. Өндөр өртөгтэй багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудлыг нэгдсэн байдлаар журамлах, орон нутагт өндөр өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэгдэж байгаа учраас засвар үйлчилгээний зардлыг төвлөрсөн байдлаар тендер хийж шийдэх

#### **ЗУРГАА: ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Нэхэмжлэлийн хяналтын үр дүнг тогтмол тайлагнах, хяналт ил тод байх, эмнэлгүүд ямар учир шалтгаанаар нэхэмжлэл хасагдсан талаарх шалтгааныг эмнэлгүүдэд болон ЭМГ-т хүргүүлж, эргэх холбоо тогтоож ажиллах
2. Эмнэлгүүд болон мэдээлэлийн технологийн компаниудын нягт хамтын ажиллагааг хангах, мөн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудыг цахимжуулах
3. Эм, эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газраас эмийн үнийн бодлого дээр тусгайлан анхаарах Эм тариа худалдан авдаг гэрээгээр эм, ханган нийлүүлэх байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх /Хар жагсаалтад оруулах асуудал/
4. Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг төвлөрүүлж зохион байгуулах, эмийн үнэ, чанар, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах, эмнэлгүүд эмийн худалдан авалтаа тусламж, үйлчилгээний төлөвлөлтэйгээ уялдуулж санхүүгийн жилтэй давхцуулахгүйгээр зохион байгуулах